

БАГААР АЖИЛЛАХ НЬ ОЮУТНЫ ХӨГЖИЛД НӨЛӨӨЛӨХ

Б.Наранчимэг, Д.Мөнхтуяа, магистр, МУБИС

Abstract: At seminar lessons students discuss many different variations of theoretical and practical problems at definite time. Students work in groups or teams under the teachers' guide, and use creative learning methods. Working in teams is helpful to increase the work result, to share methods and experience, and look at the ideas of every person from many sides. Nowadays one of the problems is that it is very important to teach students how to work in teams. So this research was made in order to organize seminar lessons in the university training program in teams, do lesson study, plan experiment lessons to help improve students' cooperative activities and to analyse the result.

There are many different studies about cooperative learning in the world. Cooperative is two or more students that work jointly and influence each other towards a certain goal.

Cooperative is member's uniting the needs, interest, ambition, activity and method. Group members support each other and work together and believe in each group's success and creation. Nowadays companies and organizations prefer the employee's cooperative skill. So students must learn cooperative skill to be a good teacher.

Therefore, I utilized experiment lessons by incorporating 'Syntax' using cooperative method and analytical results.

Түлхүүр үг: оюутны хамтын ажиллагаа, хөгжил, судалгаа, үр дүн

Удиртгал

Энэхүү өгүүлэлд бид оюутан багаар хамтран ажиллах чадвар, хамтран хөгжих боломж, бүтээлч хандлагыг сайжруулах асуудлыг судлав. Судалгааны ажлыг хийхдээ дараах судалгааны аргазүйг ашигласан болно.

- Ном, эх материал судлах арга: Онол - аргазүйн асуудлыг тодруулах
- Ажиглалтын арга: Семинар хичээлийг багаар зохион явуулах, хэрхэн ажиллаж өөрсдийгөө хэрхэн хөгжүүлж буйг илрүүлэх
- Асуулгын арга: Оюутнууд багаар ажиллахад гарсан үр дүнг тооцоход ашигласан юм.

“Семинар” гэдэг нь *seminarium* буюу “мэдлэгийн үр суулгах” гэсэн утгатай латин гаралтай үг бөгөөд их, дээд сургуулийн сургалтыг зохион байгуулах хэлбэрийн үндсэн нэг хэлбэр мөн”. (Эрдэнэцэцэг ба бус, 2011, х.191) хэмээжээ. Боловсрол судлалын чиглэлийн ном сурах бичиг болон судалгааны бүтээлүүдэд “семинар”-ын үүрэг, зорилгыг: “Лекцийн хичээлээр олж авсан мэдлэгийг өргөжин гүнзгийрүүлэх, ном сурах бичигтэй ажиллах, бие даасан ажлын чадвар дадлыг хөгжүүлэх, бие даасан бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд оршино” (Сурган хүмүүжүүлэгч, 1985, №4, х.77) гэх буюу “Оюутанд мэдлэгээ бататгах, гүнзгийрүүлэх, нэмэлт мэдээлэл олж авах, бие дааж сэтгэн бодох, суралцах болон хамтран суралцах, мэдлэг бүтээх арга барил

эзэмшүүлэх”, (Ичинхорлоо, 2012, х.115) “Онолыг гүнзгийрүүлэн судлах, шинжлэх ухааны бичлэгийг судлах дадалтай болгох, агуулгыг ерөнхийлөн дүгнэх, сэтгэхүйн шүүмжлэлт шинжийг хөгжүүлэх, мэдлэг хуримтлуулах, бүтээлч санаачилга ба чадварт суралцах, олны өмнө ярих чадвартай болох, өөрийн үзэл бодлыг хамгаалах дадал бүрдүүлэхэд чиглэдэг.” (Боловсрол судлал, 2013/9 (97), 33) гэх зэргээр тодорхойлдог. Энэхүү зорилгыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх талаар багш бүр анхаарч ажилладаг цөөнгүй бэрхшээл тулгарч байдаг. Тиймээс ч, үе үеийн эрдэмтэн, судлаачид семинарын үр өгөөжийг хэрхэн дээшлүүлэх талаар “онол-аргазүйн” судалгааг хийж, “Оюутны танин мэдэх сонирхлыг идэвхжүүлэх, тэднийг бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд чиглэгдсэн тийм арга хэлбэрийг сонгож авах нь семинарын үр дүнг дээшлүүлэх нөхцөл болно.” (Сурган хүмүүжүүлэгч, 1985, №4, х.78) “Оюутны үйл ажиллагаанд тулгуурлах, онолын мэдлэг, практик хэрэглээ хоёрыг хослуулах, арга технологи нь уян хатан байх, тэдний өнөөдрийн ба ирээдүйн хэрэгцээнд тулгуурлах, оюутанд олон талын сонголт хийх боломжийг аль болох өргөн олгох, хамтран ажиллах боломжлох, идэвх санаачилгыг дэмжих, ажил хэрэгч уур амьсгал бүрдүүлэх” (Батхуяг ба бус, 2003, х.79), “Семинарын хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд багш, оюутнуудын хэрэгцээ сонирхлыг судлах,

гэдэнтэй хамтран ажиллах, тэдний бие даасан ажлыг өрнүүлэх, бүтээлчээр сэтгэн бодох, хийж бүтээх боломж олгох нь зүйтэй” (Ичинхорлоо, 2011, х.89), “Суралцагчийн мотивацийг нэмэгдүүлснээр сургалтын үр дүн өснө гэдэг нь маргаангүй...” (Пүрэвдорж, он т- бус, х. 253) хэмээх үзэл бодол, санал дүгнэлтээ тусгаж ирсэн байдаг. Багш тулгарч буй бэрхшээлийг судалж, хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлж, сургалтандаа хэрэгжүүлснээр аливаа семинар үр өгөөжтэй болж, баг болон ажиллах нь ажлын бүтээмж нэмэгдэх, арга туршлага солилцох, хүн бүрийн санаа бодол тусгагдсан асуудлыг олон талаас нь харахад тустай хэмээн үзсэн байна.

Иймээс семинарын хичээл нь нэг талаас лекцийн хичээлийн залгамж төдийгүй нөгөө талаас оюутны бие даасан ажлаар үргэлжилнэ. Семинарын хичээл нь их, дээд сургуулийн сургалтын салшгүй хэсэг байдаг учраас семинарын хичээлийг зохион байгуулах хэлбэрийг оновчтой сонгон, зохион явуулах нь чухал болно.

Судалгааны зорилго нь оюутны багаар хамтран ажиллах чадвар, хамтран хөгжих боломж, бүтээлч хандлагыг сайжруулахад оршино. Иймд багаар хамтран ажилласнаар оюутнууд нэг нэгнээсээ суралцах дадлыг төлөвшүүлэх, багаар ажиллахын үр дүнг судлах боломж бүрдэнэ.

Баг гэдэг нь хэрэгцээ, сонирхол, эрмэлзлэл, зорилго, үйл ажиллагааны арга барилын талаарх нэгдмэл нэг ойлголт, итгэл үнэмшилтэй хамтын бүтээл амжилтын төлөө бие биенээ дэмжин, зүтгэл гарган, гар сэтгэл нийлсэн хүмүүсийн ажил хэрэгч нөхөрсөг нэгдэл юм.

Семинарын хичээлийг үр дүнтэй зохион байгуулж, оюутныг хөгжүүлэхийн тулд сургалтын бүтээлч аргуудаас аль оновчтойг нь сонгож хэрэглэх нь чухал байна.

Судалгаа, түүний үр дүн

Баг болон ажиллах нь ажлын бүтээмж нэмэгдэх, арга туршлага солилцох, хүн бүрийн санаа бодол тусгагдсан асуудлыг олон талаас нь харахад чухал ач холбогдолтой билээ. Орчин үед аль ч байгууллага боловсон хүчнийхээ нөөцийг бүрдүүлэхдээ багаар ажиллах чадварыг нэг шаардлага болгон үздэг бөгөөд өнөө үед багш болох оюутнуудыг багаар ажиллах чадварт суралцуулах явдал нэн чухал асуудлын нэг мөн. Тиймээс МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн Монгол хэл, уран зохиолын багшийн ангид судлах “Өгүүлбэр судлал” хичээлийн семинарыг багаар хамтран ажиллах арга дээр

тулгуурлан туршилт судалгааг хийв. Судалгаат хичээлийг 3 үе шаттайгаар зохион байгуулав.

I шат: Эхний 3 семинар хичээл

Эхний гурван семинарын хичээлийн /1-3/ удирдамжид, эх бичвэр дээр хамтран ажиллаж, ухаарч ойлгох 3-4 төрлийн даалгаврыг төлөвлөж оруулсан боловч семинарын явцад багийн ахлагч болон багийн 2-3 оюутны үйл ажиллагаанд юу голлох үүрэгтэй оролцов.

Хичээлийн дараа оюутнаас санал авахад:

- Оюутан бүрийг хамруулсан
- Багш даалгавар бүр дээр тайлбар өгсөн
- Оюутныг идэвхжүүлсэн
- Самбарт бичүүлсэн
- Оюутан бүрийн оролцоог хангасан гэх зэрэг олон эерэг талыг дурьдсан юм .

Цаашид анхаарах зүйл нь :

- Баг хуваарилалт
- Багаар ажиллах /нэг нэгээрээ бэлтгэхэд ярих зүйл давхцдаг/
- Оюутнууд уншиж тэмдэглэсэн зүйлээ өөрийн болгох
- Удирдамжийг 3-4 өдрийн өмнө өгөх /гүйцэт сайн бэлтгэж чадахгүй байна./
- Багийн гишүүн бүрт даалгавар оноож өгөх, оролцуулах гэх мэт зүйлийг бичсэн байсан.

Үүнээс харахад оюутнуудын 90% нь семинарын хичээлийг багаар зохион явуулах хүсэлтэй байгаа нь харагдаж байлаа.

Тэмдэглэл болон оюутны санал асуулгад үндэслэн, явцын үнэлгээ хийж, багшийн зүгээс багийн хамтын ажиллагаа, гишүүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх талаар зөвлөгөө өгч, дараа дараагийн семинарын удирдамжид тодорхой тусгаж өгсөн.

II шат: 4-10 дугаар семинар хичээл

Багийн гишүүд семинараас өмнө сэдвийг хамтран ярилцаж, оюутан удирдамжид тусгагдсан даалгаврыг хийж гүйцэтгэдэг. Семинар ахих тусам оюутны даалгавар гүйцэтгэх чадвар дээшилж, гүйцэтгэх даалгаврын тоо өсөж, 4-6 төрлийн дасгал даалгаврыг хийж гүйцэтгэсэн.

Үүний үр дүнд багийн гишүүдийн оролцоо сайжирч, хэн юу хийхээ багаараа сайн төлөвлөж, эх бичвэр болон эрдэмтдийн санал дүгнэлт, тодорхойлолтыг бүтээлчээр уншиж, эшлэл зүүлт авч тайлбарлах зэргийг бэлтгэж ирдэг болсон. Үүнд: МХУЗ –ын 3-р курсийн семинар хичээлийн I багийг жишээ болгон харуулбал:

II, VII семинар хичээлд оролцсон байдлыг харьцуулбал:

	Б.Банзрагч		Б.Алтан –Урлаг		О.Анхбаяр		Э.Багчимэг		Г.Цээсүрэн	
	II	VII	II	VII	II	VII	II	VII	II	VII
Эх бичвэрийг уншаад, нэр томъёог өөрийн үгээр тайлбарлах	3	3	1	2	2	3	3	3	1	2
Дэвшүүлсэн асуудлын талаар өөрийн үзэл бодлоо солилцож, хамтран шийдсэнээ бусдад илтгэх	2	3	1	2	1	2	2	3	1	2
Харьцуулан жишиж, ижил ба ялгаатай талыг нэгтгэн дүгнэх	3	3	1	1	1	2	2	3	1	2
Харьцаа холбоог тодорхойлох дадлага	3	3	1	2	2	3	2	3	1	2
Хэлний баримтад түшиглэн тайлбар нотолгоог гаргах	2	3	1	2	2	3	2	3	1	2

3 үзэл бодлоо илэрхийлэх, харьцуулан дүгнэх, тайлбар хийх чадвар хангалттай

2 үзэл бодлоо илэрхийлэх, харьцуулан дүгнэх, тайлбар хийх чадвар дунд зэрэг

1 үзэл бодлоо илэрхийлэх, харьцуулан дүгнэх, тайлбар хийх чадвар сул

Багийн гишүүдээс 1, 4 дүгээр оюутан семинар бүрт жигд сайн оролцож байхад 2, 5 дугаар оюутан II семинарт чадвар сул, VII семинарт чадвар дундаас дээш болсон ахицтай, 3 дугаар оюутан II семинарт чадвар дунд зэрэг, VII семинарт чадвар хангалттай болсон нь харагдаж байна.

III шат: 11-16 дугаар семинар хичээл

XI семинараас хойш оюутнуудын идэвх оролцоо, чадвар сайжирч, хичээлийг зохион байгуулахад оролцож, бэлтгэн заав. Тухайлбал:

- Тодорхойлолтыг тайлбарлах /жишээ баримтаар нотлох/
- Загварчлал гаргах /хэлзүйн гишүүн/
- Харьцуулан жишиж, нэгтгэн дүгнэх
- Ялган бүлэглэх
- Ижил ба ялгаатай талуудыг гаргах гэх мэт зүйлийг төлөвлөн, бусдад тайлбарлан

таниулж, бусад багийн гишүүдийн оролцоог идэвхжүүлэн, багшийн зөвлөсний дагуу хичээлийг хамтран заасан нь багаар ажиллах чадварыг сайн эзэмшиж байгаагийн илрэл юм.

Сүүлийн семинар хичээлүүдийн даалгавар


1. Танай багийн хамтын ажиллагааны давуу талууд?

Үүнээс харахад багийн гишүүд удирдамжийн дагуу багийн бүх гишүүд хамтран ажиллах, тухайн сэдвийг ухааран ойлгосон, өөрийн хариуцлагаа ухамсарладаг, бие биенээ сайтар ойлгож, сонсох, оногдсон даалгавраа чанартай сайн гүйцэтгэдэг, идэвхтэй оролцдог зэрэг чадварууд ахиснаас гадна багаар хамтран ажиллах чадвар дээшилсэн нь ажиглагдаж байна.

оюутан өөрсдөө мэдлэг бүтээхэд чиглэсэн, асуудал дэвшүүлсэн, нэр томъёог толь ашиглан тайлбарлаж, эргэцүүлэн дүгнэх зэрэг олон үйл ажиллагаанд чиглэсэн бөгөөд гүйцэтгэх дасгал ажлын хувилбар 6-8 төрөл болсноор багаар ажиллах чадварыг идэвхжүүлж, суралцагсад ажиглан дүгнэж ярих, асуудлыг дэвшүүлэн ярих, ижил ба ялгаатай зүйлийг дүгнэн гаргах, оюутан бүр өөрийн хийх зүйлээ ягштал бэлтгэж, цаг баримталж, хичээлд оролцдоггүй оюутнууд улам идэвхтэй, өөртөө итгэлтэй болсон зэрэг ахиц гарсан юм.


Семинар хичээлийг үр дүнтэй зохион байгуулахад нэг чухал асуудал нь судалгааны багийн гишүүн багш нар хичээлд ажиглалт судалгаа, явцын үнэлгээг хийж, хамтран ажилласан нь үр дүнгээ өгсөн юм. /5 багш/

Мөн семинарыг үр дүнтэй зохион байгуулахад оюутны бэлтгэл, багийн хамтын ажиллагаа чухал үр нөлөөтэй гэж үзлээ. Тиймээс семинар хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан аргазүйн төлөвлөлтийн үр дүнг тооцох зорилгоор энэхүү судалгааг авсан юм.



2. Танай багийн хамтын ажиллагаанд ямар бэрхшээл тулгардаг байсан бэ?

Семинарын хичээлийг багаар зохион байгуулж байхад янз бүрийн бэрхшээл тулгарч байсан бөгөөд хичээлийн үр дүнд оюутан хэрхэн яаж бэлтгэх, уншиж судлах, идэвх санаачилгатай оролцох, багаар ажиллах зэрэг чадвар нь семинарын хичээлийн явцад дээшилсэн тул 73 % бэрхшээл байхгүй гэж хариулсан байна.



3. Багаар ажилласнаар оюутан таны ямар ямар чадварууд ахиж дээшилсэн бэ? Бусдаасаа хэрхэн суралцдаг вэ?

Багаар хамтран ажилласнаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх 30 %, багаар ажиллах 29 %, бусдыгаа сонсож хамтран ажиллах 24 % зэрэг чадвар хөгжиж, бусдаасаа суралцсан нь харагдаж байна.



ДҮГНЭЛТ

Семинарын хичээлээр оюутныг оролцоог хэрхэн дэмжих судалгааг хийсний үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна.

1. Семинарын хичээлийг багаар зохион байгуулж төлөвлөлт, удирдамжийг хичээлийн судалгааны явцад оновчтой бэлтгэснээр оюутан хөгжиж байгаа нь судалгаанаас харагдаж байна.
2. Хамтран суралцахуйн давуу ба

3. Семинарын хичээлийг ямар хэлбэрээр зохион байгуулах вэ? гэсэн асуултад оюутнуудын 90-95% багаар ажиллахыг санал болгодог. Аливаа нэр томъёо, ухагдахуун ойлголт, тодорхойлолт зэрэг бэрхшээлтэй талыг тодруулж, семинарын төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлэхэд оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа чухал үүрэгтэй болно.

шинжлэх ухааны хэлийг уншиж ухаарч ойлгоход багийн хамтын ажиллагаа чухал үүрэгтэй байдаг байна.

4. Багаар ажиллахын давуу талыг оюутнууд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хамтран ажиллуулах, сурах үйл ажиллагаанд багаар оролцуулах нь багш болох оюутны хөгжилд чухал нөлөөтэй.
- Багш багийн оюутан нэг бүрийн оролцоон дээр тулгуурлан хичээлийг төлөвлөснөөр хамтын ажиллагаа хөгждөг.
- Багийн гишүүн бүрийг семинарын хичээлд идэвхтэй оролцоход чиглэсэн дасгал даалгаврыг төлөвлөдөг.
- Семинарын удирдамжид өгөгдсөн даалгаврууд нь багийн хамтын үйл ажиллагааг хөгжүүлэхийг зорьдог. / Зайлшгүй багаараа хийх хэрэгтэй болдог/
- Оюутан бүр эх бичвэр дээр ажиллах, загвар графикийг ажиглан тайлбарлах, оногдсон даалгавраа сайтар гүйцэтгэх, хамтран ажиллах, эргэцүүлэн дүгнэж ярих, ойлгосноо бусдадаа тайлбарлах, идэвх санаачилгатай оролцох, бусдыгаа хүндэтгэх зэрэг олон чадвар хөгждөг.
- Баг болж ажилласнаар оюутан хөгжих бүрэн боломжтой бөгөөд ном, сурах бичигтэй хэрхэн яаж ажиллах, хичээлд бэлтгэх, бусдыг сонсох, өөрийгөө илэрхийлэх, ярих чадвар сайжирсан зэрэг ахиц гардаг.
- Багаар ажилласнаар анги хамт олны хамтын ажиллагаа сайжирдаг.
- Багийн хамтын ажиллагаа, семинарын үр өгөөжийн талаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг авч, багийн гишүүдэд зөвлөгөө өгдөг нь багийн оюутнуудын харилцаанд сайнаар нөлөөлдөг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Батхуяг, С., Ичинхорлоо, Ш. (2000). Сурган хүмүүжүүлэх зүй. Улаанбаатар: Мөнхийн үсэг
- Боловсролын хүрээлэн. (2013/9). *Боловсрол судлал 96*. Улаанбаатар
- Боловсролын хүрээлэн. (2013/9). *Боловсрол судлал 97*. Улаанбаатар
- Ичинхорлоо, Ш. (2009). *Шавь төвтэй хичээлийн технологи*. Улаанбаатар: Soyombo printing
- Ичинхорлоо, Ш. (2011). *Дээд сургуулийн сургалт онол аргазүй*. Улаанбаатар: Soyombo printing
- Ичинхорлоо, Ш. (2012). *Хамтран ажиллах ухаан*. Улаанбаатар: Soyombo printing
- Ичинхорлоо, Ш. (2013). *Судалгааны ажлын үндэс*. Улаанбаатар
- Ичинхорлоо, Ш. (2013). *Сургалтын аргазүйн шинэчлэл. (4 дэх удаагийн)*. Улаанбаатар
- Ичинхорлоо, Ш. (2013). *Сургалтын онол, хэрэглээ*. Улаанбаатар
- Пүрэвдорж, Ч. (2010). *Багшлахуйн менежмент*. Улаанбаатар: Мөнхийн үсэг
- Боловсролын хүрээлэн. (1985). *Сурган хүмүүжүүлэгч, №4*. Улаанбаатар
- Эрдэнэцэцэг, С., ба бус. (2011). *Багш боловсролын үндэс*. Улаанбаатар.
- Тэгшжаргал, Н.(2009). *Багаар ажиллах эрдэм*. Улаанбаатар.
- Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар.